
УЛААНБААТАР
ХОТЫН
ДААТГАЛ



ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2022 он

“Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн ТУЗ-ийн
2022 оны үйл ажиллагааны тайлан

ТУЗ-ийн хурал

“Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 онд ээлжит хурлыг 3 удаа зохион байгуулсан ба хурлын товд өөрчлөлт орсон тохиолдол байхгүй болно.

№	Огноо	Хурлууд	Товч агуулга
1.	2022/9/22	ТУЗ-ийн ээлжит хурал	Үнэт цаасны данс нээлгэх
2.	2022/10/3	ТУЗ-ийн ээлжит хурал	Хороодын бүрэлдэхүүн батлах
3.	2022/12/5	ТУЗ-ийн ээлжит хурал	Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг батлах

ТУЗ-ийн хурлын байршил

ТУЗ-ийн хурал нь “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн төв салбарын хурлын танхимд зохион байгуулагдсан ба товолсон байрлалд өөрчлөлт ороогүй болно.
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Ж.Самбуугийн гудамж, М Плаза оффис, 5 давхар, 500 тоот

ТУЗ-ийн хурлын агуулга, шийдвэр

1. 2022/9/22-ний өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.
   - “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн үнэт цаасны дансыг нээлгэх;
   - Үнэт цаасны данс дах хөрөнгийг захиран зарцуулах этгээдийг томилох.
     ТУЗ-ийн гишүүд санал нэгтэйгээр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-д үнэт цаасны данс нээлгэж, захиран зарцуулах этгээдээр Гүйцэтгэх захирал М.Энхболдыг томилов.

2. 2022/10/3-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.
   - ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг батлах;
   - ТУЗ-ийн хороодыг удирдах ажилтныг томилох.

Хурлын өмнө “Аудитын хороо”, “Эрсдэлийн удирдлагын хороо”-г ахлан ажиллах ажилтнуудын анкеттай танилцсан болно. ТУЗ-ийн гишүүд нь санал нэгтэйгээр “Аудитын хороо”, “Эрсдэлийн удирдлагын хороо”-ны бүрэлдэхүүн болон удирдах ажилтныг томилов.

3. 2022/12/5-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.
   - “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх арга, аргачлалын төслүүдийг хэлэлцэх батлах.

     Хурлын өмнө СЗХ-ны холбогдох журамтай танилцан Актуарч О.Дүдарийгаас тодруулга авав. ТУЗ-ийн гишүүд баримт бичгүүдтэй танилцан санал нэгтэй баталсан.

ТУЗ-ийн хурлаар батлагдсан хавсралтууд

1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн “Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг” – Хавсралт №01
2. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн “Эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх арга, аргачлал”- Хавсралт №02